

БАТЛАВ  
БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА *Мунд* Л.ЦЭДЭВСҮРЭН

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ, ЕСӨНБУЛАГ СУМЫН ХАНТАЙШИР-ЭРДЭМ  
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН 640 СУУДАЛТАЙ БАРИЛГЫН ХОЛБОЛТЫН  
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын 2022 оны Засгийн газрын 460 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт</li> <li>- 2023 оны төсвийн тухай хууль;</li> <li>- Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/16 дугаар тушаал.</li> </ul>
2.	Барилга байгууламжийн байршил, эдэлбэр газрын хэмжээ	Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Оргил баг Эдэлбэр газар 5449 мкв
3.	Зориулалт, хүчин чадал /нэг маягийн зураг төсөл/	Зориулалт: Сургуулийн барилга Хүчин чадал: 640 суудалтай
4.	Барилгажих талбайн эзлэх хувь	Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/-ийн дагуу төлөвлөх.
5.	Үлгэрчилсэн ерөнхий төлөвлөгөө, эдэлбэр газар, тохижилтод тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Эдэлбэр газрын хэмжээг нэг хүүхдэд ногдох талбай холбогдох норм, дүрмийн дагуу тооцож төлөвлөх;</li> <li>- Эдэлбэр газрын талбайг дотор нь биеийн тамир, аж ахуйн ба амралт, сургалт, туршилт тоглоомын талбай гэсэн 5 үндсэн бүсэд ангилан төлөвлөх;</li> <li>Гадаа спорт талбай, амралтын талбай, хүүхдүүдийн тоглоомын талбайтай байхаар төлөвлөх;</li> <li>- Спорт тоглоомын талбай нь резинэн эсвэл хатуу хучилттай, хөл бөмбөгийн талбай нь зүлэг байхаар төлөвлөх;</li> <li>- Иргэдийн түр цугларах аюулгүйн талбай, гамшгийн зарлан мэдээллийн дуут цамхаг болон дадлага сургууль зохион явуулах цэг төлөвлөх.</li> <li>- Амралтын бүсийг ногоон байгууламжтай зэрэгцээ аж ахуйн болон биеийн тамирын талбайгаас төлөвлөлтийн боломжоор зайтай төлөвлөх;</li> <li>- Хог цуглуулах талбай руу орох орц бие даасан, хүрэх зам нь хатуу хучилттай, хог цуглуулах талбай нь хаалт бүхий тусгаарлагчтай байх;</li> <li>- Эдэлбэр газрын талбайд холбогдох норм, дүрмийн шаардлагын дагуу ногоон байгууламж төлөвлөх;</li> <li>- Сургуулийн эдэлбэр газар нь 1.6м-ээс багагүй өндөртэй ногоон байгууламж эсвэл хашаагаар хүрээлэгдсэн байх;</li> <li>- Ерөнхий боловсролын сургуулийн барилгаас тухайн сургуульд хамааралтай авто зогсоол тооцож төлөвлөх; /Авто машины зогсоолыг хашааны гадна төлөвлөх/</li> <li>- Эдэлбэр газрын талбайн гэрэлтүүлгийг холбогдох норм, дүрмийн дагуу төлөвлөх;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Авто зам, тээврийн хэрэгслийн зогсоол, явган хүний гарц, гамшгийн үеийн цугларах аюулгүй талбайг холбогдох стандартын дагуу төлөвлөх;</li> <li>- Барилгын орчны байгууламж руу очих явган хүний зам хатуу хучилттай байхаар төлөвлөх.</li> </ul> <p><b>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтөд тавигдах шаардлага:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй зорчиход зориулж холбогдох норм, дүрмийн шаардлагын дагуу төлөвлөх;</li> <li>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто зогсоол төлөвлөх;</li> <li>- Явган хүний зам нь хатуу, нягт, халтирахаас сэргийлсэн гадаргуугаар хийгдсэн байх бөгөөд хөтөч хавтан төлөвлөх;</li> <li>- Гол орц, гарц хэсэгт тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан алгуур налуу бүхий налуу замыг БНБД-ийн дагуу 1:12 төлөвлөх/;</li> <li>- Онцгой нөхцөлд ашиглах орц, гарц төлөвлөх.</li> <li>- “Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” /БНБД 30-01-04/</li> <li>- Сургалт хүмүүжлийн барилга байгууламж БНБД II-66-88-ын Хавсралт 7.</li> </ul>
6.	Инженер шугам, сүлжээнд тавигдах шаардлага, эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> <li>- Хоёр оновчтой хувилбараар холбогдох норм, дүрэм, стандартын дагуу төлөвлөх.</li> <li>А. Техникийн нөхцөлийн дагуу төвийн шугам сүлжээнд холбох</li> <li>Б. Дэвшилтэд технологи бүхий байгаль орчинд ээлтэй хувилбараар бие даасан байдлаар шийдвэрлэх.</li> <li>- Ундны усны өөрийн эх үүсвэрийн худаг гаргаж байгаа тохиолдолд худгийн эргэн тойрон 50м-т эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож хашаажуулах зай талбайг хангалттай төлөвлөх;</li> <li>- Ус нөөцлөх савыг зориулалтын, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн материалаар хийх, ус нөөцлөх савыг халаалтын зуухнаас тусдаа өрөө тасалгаанд таазанд тулгахгүйгээр угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэлт явуулах боломжтой, агаарын солилцоо хийгдэх боломжтой байхаар төлөвлөх;</li> <li>- Бохир ус цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламжтай бол зай талбайн хэмжээг тооцох, цэвэрлэсэн бохир усыг цооногт цуглуулж хөрсөнд хаяхгүй зөөвөрлөхөөр төлөвлөх;</li> <li>- Бохир ус цуглуулах цооногийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын А/82/128 хамтарсан тушаалаар батлагдсан Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журмын дагуу зураг төслийг хийсэн байх.</li> </ul>
7.	Инженер-геологийн судалгааны талаарх шаардлага	Тухайлсан байршилд инженер геологийн дүгнэлтийг гаргуулж, баталгаажуулах
8.	Газар хөдлөлийн эрчим	Газар хөдлөлийн 6, 7, 8, 9 баллаас байршилд тохирохыг Инженер-геологийн судалгаанд үндэслэн сонгоно.

9.	Инженерийн бэлтгэл арга хэмжээ /үерийн хамгаалалт, далан, суваг шуудуу, ус зайлуулах шугам сүлжээ/	Холболтын зураг төслийг боловсруулахад /үерийн хамгаалалт, далан, суваг шуудуу, ус зайлуулах шугам сүлжээ/ анхаарах
10.	Барилгын улаан шугамын зай	Шаардлагагүй
11.	Байгаль орчны үнэлгээ, нөхцөл	Шаардлагагүй.
12.	Зураг төслийн бүрдэл	<ul style="list-style-type: none"> <li>• Загвар зураг</li> <li>• Ажлын зураг</li> <li>- Үлгэрчилсэн ерөнхий төлөвлөгөө</li> <li>- Барилга архитектур</li> <li>- Технологийн зураг</li> <li>- Барилга бүтээц /Бүтээцийн тооцоо/</li> <li>- Дотор халаалт, агаар сэлгэлт</li> <li>- Дотор цэвэр бохир ус</li> <li>- Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг</li> <li>- Холбоо дохиолол</li> <li>- Автоматик, удирдлагын зураг төсөл</li> <li>- Барилгын эрчим хүчний гэрчилгээ</li> <li>• Төсөв – магадлал хийсэн ажлын зураг төслийн дагуу төсвийг программаар гүйцэтгэх.</li> <li>• Мэргэжлийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, зөвлөмж,</li> <li>• Барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийсэн дүгнэлт</li> <li>• Барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын хяналт хийсэн тухай дүгнэлт</li> <li>• Ажлын зургийн магадлалын дүгнэлт.</li> </ul> <p><b>Ажил гүйцэтгэх аргачлал:</b></p> <p>- Барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, орчны тойм, эзлэхүүн төлөвлөлт, барилгын нүүр тал /фасад/, өнгөний шийдэл, төлөвлөлтийг тодорхойлсон загвар зургийг боловсруулж барилгын асуудал хариуцсан байгууллагаар хянуулах;</p> <p>- Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн дагуу боловсруулж, загвар зураг болон магадлал хийлгэсэн ажлын зураг, төсвийг холбогдох баримт бичгүүдийн хамт эх хувь 1 хувь, хуулбар 3 хувь, файл /autocad, pdf, төсөв зохиосон программын өргөтгөлтэй/ хэлбэрээр CD-д бичиж 1 хувь хүлээлгэн өгнө.</p>
13.	Зургийн үе шат, хугацаа	<ul style="list-style-type: none"> <li>- Нэг үе шаттай</li> <li>- Ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу</li> </ul>
14.	Хөрөнгө оруулагч	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
15.	Захиалагч байгууллага	Боловсрол, шинжлэх ухааны яам
16.	Зураг төслийн ажлыг боловсруулахад ашиглах материал	<p><b>Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд:</b> Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад шаардагдах хууль, тогтоомжууд.</p> <p><b>Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн хүрээнд:</b></p>

		<p>Холбогдох хүчин төгөлдөр мөрдөгдөж буй барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, стандарт, төсөл, хөтөлбөр, дүрэм, журмыг баримтална.</p> <p>Мөн доорх норм, дүрмийн шаардлагыг тусгасан байна. Үүнд:</p> <p>-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2015 оны А/253/251/173 тоот хамтарсан тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага"</p> <p>-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалаар баталсан "Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм"</p> <p>- Хүүхдийн тоглоомын талбай.Ерөнхий шаардлага MNS 6751:2019</p>
17.	Галын аюулгүй байдлын нөхцөл	<p>- Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал БНБД 21-01-02</p> <p>- Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21-02-02</p>
18.	Эдийн засгийн тооцоо, төсөв	<p>- Зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох</p> <p>- Төсөвт – тээврийн зайг Улаанбаатар хотоос тооцох</p>
19.	Зөвшилцөх байгууллага	<p>- Боловсрол, шинжлэх ухааны яам</p> <p>- Эрүүл ахуй, галын аюулгүй байдлын асуудал хариуцсан байгууллага</p> <p>- Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллага</p>

**ХЯНАСАН:**

БШУ-ны яамны Санхүү, Хөрөнгө оруулалтын газрын дарга:

БШУ-ны яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга:

Боловсролын ерөнхий газрын дарга:

БШУ-ны яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах шинжээч:

**БОЛОВСРУУЛСАН:**

БШУ-ны яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн:

БЕГ-ын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн

БЕГ-ын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт зохицуулалтын газрын мэргэжилтэн



О.ХУЯГЦОГТ

С.НАНСАЛМАА

Т.НЯМ-ОЧИР

Ч.БАТБОЛД

Ш.ЭНХТУУЛ

Б.АМАРЗАЯА

Л.ТӨРТОГТОХ